



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/520

Чингис хот

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлсэнтэй холбогдуулан авах арга
хэмжээний талаар

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 12 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын №34 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусын халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Ерөнхий боловсролын сургууль болон Политехникийн коллеж, Бор-Өндөр сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны сурагчдыг ар гэрт нь аюулгүй байдлыг хангуулж, нэгдсэн зохион байгуулалтаар буцаах ажлыг зохион байгуулахыг Боловсрол, соёл урлагийн газар /С.Мөнхцэцэг/, татан авах ажлыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2. Мал, мах, өргөн хэрэглээний хүнс, хүнсний тээвэрлэлт хийх автомашинд тусгай зөвшөөрлийг олгох, нөөцийг тодорхойлох, нөөцлөхийг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ж.Энх-Амгалан/, Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/, халдвар хамгааллыг чанд мөрдүүлэхийг Эрүүл мэндийн газар /Д.Баасандорж/-т тус тус даалгасугай.

3. Халдварын үед хэрэглэгдэх шаардлагатай эмийн жагсаалтыг нэгдүгээр, COVID-19 хурдавчилсан оношлууртай сумдын үйлчлэх хуваарийг хоёрдугаар, Мал мах тээвэрлэх журмыг гуравдугаар хавсралтаар тус тус батласугай.

4. Коронавирусын халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай эмийн зардалд 20.000.000 /хорин сая/ төгрөгийг гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

2.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Шуурхай штабын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

Аймгийн Засаг даргын 2020 оны
 11 дугаар сарын 16 өдрийн 1/Б.20
 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

"КОВИД-19" ХАЛДВАРЫН ҮЕД ХЭРЭГЛЭГДЭХ
 ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН ЖАГСААЛТ

Вирусийн эсрэг эмүүд	Хэмжих нэгж	тун	хоногт	Үргэлжлэх	1 хүнд	10 хүнд	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Дархлаа дэмжих								
Interferon-b, a	Виферон лаа	1 сая	1 сая	10	10 сая	100 сая	3,800	380,000
Антибиотик								
левофлоксацин	шахмал	250	1*2	7	14	140	1,400	196,000
левофлоксацин	шахмал	500	1*2	7	14	140	2,209	309,260
амоксациллин клавуланат	капсул	250/125	1*2	7	14	140	750	105,000
		500/175	1*2	7	14	140	2,410	337,400
имипенем	фл	1 сая	2-3 сая	7	14-21	140-221	80,000	17,622,340
цефепим	фл	1 сая	3 сая	7	14-21	140-210	5,000	1,050,000
Нийт								20,000,000

Аймгийн Засаг даргын 2020 оны
... дугаар сарын ... өдрийн ...
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

КОВИД-19 ХУРДАВЧИЛСАН ОНОШЛУУРЫН ХУВААРЬ

№	Хурдавчилсан оношлууртай сумд	Өмнөх нөөц	COVI-19 sungentech SGT Дуусах хугацаа 2021.04.05	Үйлчлэх хүрээ
1	Биндэр		25	Баян-Адарга
2	Бэрх		25	Батноров
3	Бор-Өндөр	620		Дархан
4	Өмнөдэлгэр		25	Гурванбаян
5	Жаргалтхаан	25		
6	Галшар		25	
7	Баянмөнх		25	
8	Дэлгэрхаан	25		Хэрлэнбаян-Улаан
9	Цэнхэрмандал	25		
10	Батширээт		25	
11	Норовлин		25	Дадал
12	Баян-овоо		25	
13	АНЭмнэлэг	20	200	Баянхутаг, Мөрөн, Хэрлэн
14	ЗӨСТ	100		
15	ЭМГазар		800	
16	Дүн	815	1200	Бүгд-2015

Мал, мах тээвэрлэх журам

1. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг сум, аймгийн нутаг дэвсгэрээс гарган зах зээлд нийлүүлэх, худалдан борлуулах тохиолдолд гэрээт Мал эмнэлгээс мал эмнэлгийн гэрчилгээ заавал авна. Хэрэв гэрээт мал эмнэлгийн эмч байхгүй тохиолдолд тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бусад Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид малын өрхийн эрүүл мэндийн дэвтэрээ үзүүлж гэрчилгээ авах

2. Зах зээлд борлуулах, хүнсэнд хэрэглэх мал, малын гаралтай бүтээгдэхүүнд үзлэг хийсэн малын эмчийн тодорхойлолтыг үндэслэн Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч хянаж баталгаажуулалт хийсний дараа гэрчилгээг гэрээт малын эмч эсвэл Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн малчинд хэвлэж өгөх

3. Гэрчилгээ олгож буй малын эмч нь тухайн сумын нутаг дэвсгэрээс гадагш шилжилт хөдөлгөөн хийх мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний хүрэх газар, дамжин өнгөрөх мал эмнэлгийн хяналтын цэг, тээвэрлэх маршрут зэргийг мал эмнэлгийн гэрчилгээний системийн мэдээллийн санд оруулах

4. Тээвэрлэгч нь орон нутгаас хэвлэж өгсөн цахим гэрчилгээг үрэгдүүлсэн бол хяналтын цэгийн мал эмнэлгийн улсын байцаагч төв мэдээллийн санд мэдээлэл илгээсэн улсын байцаагчтай холбогдож үнэн бодит байдлыг нягтлан шалгаж анх олгосон этгээдийн цахим зөвшөөрлөөр гэрчилгээг газар дээр нь нөхөн олгох

5. Ковид-19-ын халдвартай холбоотойгоор хорио цээрийн дэглэм хэрэгжиж байгаа үед төв, суурин газарт орох хөдөлгөөнийг багасгах үүднээс зөвхөн идшинд хэрэглэх мах, амьд малд гэрчилгээний код өгөх ба энэ тохиолдолд малын эмч малчнаас авсан мэдээллийн дагуу цахим системд арьс, толгойны зураг болон амьд малын зураг, им, тамга, зүс содон тэмдэгийг дэлгэрэнгүй оруулах. Цахим гэрчилгээний тайлбар хэсэгт идшинд гэсэн тодотгол оруулах

6. Идэш тээвэрлэлтийг сумдаас нэгдсэн зохион байгуулалтаар аймаг Улаанбаатарын чиглэлд тээвэрлэх дээ тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичгийг тус тус үндэслэж явуулах